



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 1102

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дах заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9, 4 дүгээр хэсгийн 4.4.20 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Засгийн газрын 2011 оны 108 дүгээр тогтоолоор батлагдсан “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хамтран боловсруулсан “Үндэсний хэмжээнд зоонозын халдварт өвчний хүн, мал эмнэлгийн салбар дундын зөвлөл”-ийг бэхжүүлэх удирдамжийг хэрэгжүүлэх, “Аз жаргалтай хот” хөтөлбөрийн хүрээнд золбин нохой, муургүй–Улаанбаатар болгох ажлын хөтөлбөрийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Т.Батбаяр	Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Н.Цогбадрах	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал
	Ү.Хосбаяр	Улаанбаатар хотын цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтсийн дарга, дэд хурандаа
	А.Нарантуяа	Нийслэлийн мал эмнэлгийн газрын дарга
	Д.Энхсайхан	Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГазрын дарга
	Б.Гүнчин-Иш	Улаанбаатар хотын цагдаагийн газрын ахлах мэргэжилтэн
	С.Аригуун	Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Гантөмөр	Нийслэлийн Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн
	С.Баяр	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн мэргэжилтэн

111030044

	Ц.Зориглон	Азтай савар ТББ-ын тэргүүн
	О.Октябрь	Бид судлаачид ТББ-н тэргүүн
	С.Орхонбаяр	Шинэ хэмнэл констракшн ХХК-ий захирал
	М.Гантөгөлдөр	Базалт нэгдэл ХХК-ий захирал
Нарийн бичгийн дарга	Т.Энх-Амгалан	Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн төлөвлөгөөг 2016 оны 10 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг Ажлын хэсэг /Т.Батбаяр/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ӨРДӨН
ГҮЙЦЭТГЭГЧ *T. Ganter* Т.ГАНТӨМӨР

